

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙН ҮР ДҮН

АУДИТЫН КОД: БУА-2021/06-ШТА-ГА

Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны чанар, дотоод хяналтын баг нэг удаагийн сарын аяны ажлаас өөр хяналт шалгалт зохион байгуулаагүй, биелэлтийг тооцож ажилладаггүй, бусад илэрсэн зөрчлүүдээс дүгнэхэд байгууллагын үйл ажиллагааны дотоод хяналт сул, үр дүн, үр нөлөө бага байна.

БУЛГАН АЙМАГ 2021 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn
Аудитын менежер Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор П.Мөнхтуяа
Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn
Аудитор Б.Энхтөр
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	4
Хүснэгтийн товьёг	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6-7

БҮЛЭГ А.

А.1 Нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээ тогтолцоо, ажлын төлөвлөгөөг төлөвлөж ажилладаг ч орон тоог 100 хувиар батлуулан ажиллаагүй байна.....8

А.1.1 Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд төлөвлөн ажиллажээ.....8

А.1.2 Эмнэлгийн тусламж, үйлчилгээг хэвийн явуулахад хүний нөөцийн хангалт дутуу, 80 хувийн орон тоогоор үйл ажиллагааг явуулсан байна.....8-9

А.1.3 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн 2020 оны судалгаагаар 230.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж шаардагдсанаас 18.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж ажилласан байна.....9-11

А.2 Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээний бэлэн байдлыг хууль, дүрмийг үндэслэн тушаал шийдвэрийн дагуу холбогдох журмуудыг батлан гаргасан байна....11

А.2.1 Яаралтай түргэн тусламж үйлчилгээний болон дуудлагаар ажиллах эмнэлгийн холбогдох журмуудыг байгууллагын даргын тушаалаар батлан мөрдлөг болгон ажиллажээ.....11-12

А.2.2 Яаралтай түргэн тусламж үзүүлэхэд шаардлагатай эм, багаж хэрэгслийн, автомашин, тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, дуудлагын бүртгэл, жолоочийн тооцооны замын хуудас шатахууны тооцоог бүрэн хөтөлдөг ч түргэн тусламжийн дуудлагын бүртгэлийг дутуу хөтөлсөн, холбогдох журмуудыг мөрдлөг болгож ажиллаагүй байна.....12

А.3 Хоол хүнсний хангалт, нийлүүлэлт эрүүл ахуйн шаардлага бүрэн хангаагүй байна.....12

А.3.1 Эмнэлгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ нь хэвтэн эмчлүүлэгчдэд норм нормативын дагуу хүрч ажиллаж байгаа ч 56218.9 мянган төгрөгийн мах, махан бүтээгдэхүүнийг гэрээ байгуулаагүй худалдан авалт хийжээ.....12-13

А.3.2 ТБОНӨБАҮХАТ хуулийг зөрчин Нэгдсэн эмнэлгийн хоол хүнсний материалыг шууд гэрээ байгуулан бэлтгэн нийлүүлж ажиллажээ.....13-14

А.4 Төлбөртэй үйлчилгээ орлого бүрдүүлэлт хангалттай байна.....14

А.4.1 Төлбөртэй тусламж үйлчилгээний орлогыг өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан төсөвт батлуулж ЭМДС-гаас 3585 хэвтэн эмчлүүлэгчийн 1083.1 сая төгрөгийн санхүүжилт авчээ.....14-15

А.4.2 Төлбөртэй тусламж үйлчилгээний 82611.5 мянган төгрөгийн орлогоор санхүүжсанаар статистик мэдээг тайлагнажээ.15

А.5 Аюултай хог хаягдлыг устгах үйл ажиллагаа хууль журмын дагуу зохион байгуулагджээ.....15

А.5.1 Эмнэлгийн аюултай хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгахад холбогдох дүрэм, журмыг мөрдөж байгаа ч хяналтын байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлсэн байна.....15-16

Б. Нэгдсэн эмнэлгийн дотоод хяналтын баг нь тухайн жил хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулан ажиллаагүй байна.....16

Б.1 Эмийн зарцуулалт тавих шат шатны хяналт сул байна.....16

Б.1.1 Эмнэлэгт хэрэглэгдэх эмийн жагсаалтыг жил бүр гарган, хэрэгцээний зэрэглэлээр ангилах, эмийн эмчилгээг зохицуулах хороог байгуулан ажиллажээ.....16-17

Б.1.2 Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, хэрэглээ, хадгалалт, хамгаалалт зарцуулалтад хяналт тавьж ажиллаж байгаа ч зарим тасгийн эмийн зарцуулалтын тайлан илүү, дутуу зөрүүтэй тайланагдаж байна.....17

Б.2 Чанарын хяналтын багийн гишүүд хяналт шалгалт хийсэн тохиолдол бүрд дүн шинжилгээ хийж, оновчтой сургалт зохион байгуулбал байгууллагын үйл ажиллагаа, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн баталгаа нэмэгдэх бололцоотой нь харагдаж байна.....17

Б.2.1 Байгууллагын дотоод хяналт шалгалтын баг, жилийн ажлын төлөвлөгөө батлуулаагүй, нэг удаагийн сарын аяны ажлаас өөр хяналт шалгалт зохион байгуулаагүй байна.....17-18

Б.2.2 Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгаж байгаа хэдий ч өгсөн зөвлөмж, алдаа зөрчлийн биелэлтийг тооцдог, давтан шалгалтыг хийдэг байх шаардлага үүсэж байна.....18-19

Дүгнэлт.....19-20

Зөвлөмж.....20

Мэдэгдэл.....20



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/13

Булган

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 3.2 дахь заалт, 2018 оны А/221 дүгээр тушаалаар баталсан "Аудитын чанарын хяналтын журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Булган аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу " Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар хүртээмжийн үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Гүйцэтгэлийн аудитын тайланг аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргад хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2021 оны 12 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Оюунцэцэг, орлогч дарга У.Энхмаа нарт даалгасугай.
4. Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь хангуулж, биелэлтийг тооцон хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ж.Энхцоодол/-д даалгасугай.
5. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, Төрийн аудитын байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд түгээхийг ахлах аудитор /П.Мөнхтуяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D: /bnchig hereg/2021/tushaai/TAtushaai.doc

006010040

Товчилсон үгийн тайлбар

НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
ЭМТХ	Эрүүл мэндийн тухай хууль
ЭТҮТХ	Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
ХХТХ	Хог хаягдлын тухай хууль
ЭЭХТХ	Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
НЭ	Нэгдсэн эмнэлэг
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Эмнэлгийн тусламж, үйлчилгээг хэвийн явуулахад хүний нөөцийн хангалт дутуу, 78 хувийн орон тоогоор үйл ажиллагааг явуулсан байна.	7
Хүснэгт 2	Нэгдсэн эмнэлэгт 2020 онд худалдаж авсан болон төсөл хөтөлбөр, хандив тусламжаар орлогод авсан машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын жагсаалт	8
Хүснэгт 3	Булган аймгийн НЭ-т 2020 онд шаардлагатай, дутагдаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн жагсаалт	9
Хүснэгт 4	Нэгдсэн эмнэлгийн хоол хүнсний жилийн эцсийн үлдээгдэл	11

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Ковид-19, цар тахалтай холбогдуулан хийгдээгүй, цахим хаягаар нөхцөл байдлын зургийг холбогдох ажилтнаар авч баталгаажуулан ажилласан	10
Зураг 2	Хог хаягдлын байр, болон хогийн савны ангилал	14
Зураг 3		
Зураг 4		

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Төрийн аудитын газрын 2021 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу “Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар хүртээмжийн үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийлээ.
Аудитын зорилт	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар хүртээмжийн үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцууллага иргэд олон нийтэд мэдээлэхэд зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, үр нөлөөтэй эсэх. - Дотоод хяналтын үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байна уу?
Аудитын хамарсан хүрээ	Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 оны үйл ажиллагаа, үйлчилгээ, үр дүн, үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт, ажлын гүйцэтгэлд хяналт хийсэн ажлын тайлан, мэдээнд үндэслэн хийнэ. Тус байгууллагад хамааралтай чиг үүрэг бүхий аймаг, сумдын Засаг дарга, түүний харъяа яам, байгууллага, гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулна.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 300, АДБОУС 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт, гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах бөгөөд шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, холбогдох асуудлаар байгууллага ажлын хэсгийн ажилтнуудаас асуулга авах, судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж асуудлын шинжилгээ, арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулна. Аудитын асуудлын шинжилгээг хавсралт-5, арга зүйг 5, аудитын хөтөлбөрийг 6 хүснэгтээр тус тус үзүүлэв.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хянан удирдаж, менежер Ж.Энхцоодол үе шатны чанарын хяналтыг хийж, ахлах аудитор П.Мөнхтуяа, П.Содном, аудитор Б.Энхтөр, Г.Цэрэнлхам, Д.Даариймаа, Э.Одбаясах нар хийж гүйцэтгэлээ. Аудитын удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудитыг 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэл гүйцэтгэж үе шатны хяналтыг хийлгэн, гүйцэтгэлийн аудитын тайланг холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажиллалаа.

Хүндрэл бэрхшээл

Аудит хийх ажлын хоног боломжийн боловч ковид-19, цар тахал өвчинтэй холбогдуулан аудитад шаардагдах баримт материал дутуу, талбар дээр ажил хийгдэхгүй, ажил удаашрах эрсдлүүд үүссэн болно.

А.Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд тоног төхөөрөмж, хүний нөөцийн хангалт дутуугаас үр нөлөө бага гэж дүгнэгдэж байна.

А.1 Нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээ тогтолцоо, ажлын төлөвлөгөөг төлөвлөж ажилладаг ч орон тоог 100 хувиар батлуулаагүй байна.

А.1.1 Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд төлөвлөн ажиллажээ.

Нэгдсэн эмнэлэг нь 2020 онд 5 зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулахаар гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 хөтөлбөрөөр нийт 37 төрлийн ажлыг төлөвлөжээ.

Үүнд:

1. Нийгмийн эрүүл мэндийн олон талт арга хэмжээг хэрэгжүүлж эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх.
2. Эмч, эмнэлгийн ажилтны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.
3. Сувилагч, эх баригч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн үйл ажиллагааг дэмжих.
4. Эх, хүүхдийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний эрсдэлийг бууруулан, аюулгүй байдлыг хангаж, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах.
5. Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын зэргийг дээшлүүлнэ гэсэн 5 зорилт дэвшүүлж ажилласнаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ажил тус бүрээр дүгнэн нийт ажлын хэрэгжилтийг 98.4 хувьтай хэрэгжсэнээр тооцсон гэж цахимаар авахад тамга, тэмдэг, гарын үсэггүй материал ирүүлсэн нь хангалтгүй байсан тул шалгалтын үеэр удаа дараа холбогдох хүний нөөцийн менежер болон орлогч даргаас гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлтийг эх хувиар нь мөн ЭМГ-аас биелэлтийг тооцож ажилласан тухай тэмдэглэл, албан тоотыг цаасаар болон цахимаар ирүүлэхийг шаардсан боловч холбогдох баримт материалыг ирүүлээгүй нь ковид-19, цар тахалтай холбон үзэж байгаа ч холбогдох асуудлыг дүгнэх боломжгүй, хийсэн ажлыг хийгээгүйгээр дүгнүүлэх зэрэг эрсдэл үүсгэж, Төрийн аудитын тухай хуулийн 42.1 дэх¹ заалтыг мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллаагүй тул холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

А.1.2 Эмнэлгийн тусламж, үйлчилгээг хэвийн явуулахад хүний нөөцийн хангалт дутуу, 80 хувийн орон тоогоор үйл ажиллагааг явуулсан байна.

Нэгдсэн эмнэлэг нь 2020 оны байдлаар хүний нөөцийг “Бүтэц орон тоог нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны MNS 5095:2017 стандарт”-ын дагуу төлөвлөж шаардагдаж байгаа орон тоог 314 төлөвлөн хүргүүлж ажилласан боловч тухайн онд 251 орон тоогоор баталж, 63 орон тоогоор дутуу байна.

Дутагдалтай орон тоог хүснэгтээр харуулбал:

№	Төрөл	Дутагдалтай орон тоо	Тайлбар
1	Эмч, сувилагч	55	Хүлээн авах ЯТТ, төрөх эмэгтэйчүүд
2	Стандартаас гадуурх зохистой бүрдүүлэлт	8	Амбулатори, оношилгоо, туслах сувилагч
Нийт дүн		63	

Дээрх хүснэгтээс дүгнэхэд Нэгдсэн эмнэлгийн хүний нөөц болон орон тоо 2020 онд 80 хувийн орон тоогоор үйл ажиллагааг явуулж байгаа нь эмнэлгийн ажилчдын ачаалал ихсэх, эмнэлгийн үйл ажиллагаа бүрэн хэмжээгээр ажиллахгүй доголдол үүсэх магадлалтай байна.

Байгууллагын бүтэц орон тооноос үйлчилгээний албан хаагчдын хүрэлцээ, цэвэрлэх талбайг стандартын дагуу тооцож Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаа явуулж байгаа нийт байрны 7842.4 кв талбайд нэг үйлчлэгчийг хулдаасан шалны нормыг 260-315 кв буюу дунджаар 280 кв талбай цэвэрлэхээр тооцож 29 үйлчлэгч шаардлагатайгаар төлөвлөн ажиллажээ.

Энэ нь стандартад тусгагдсан хэмжээгээр хулдаасан шалны нормоор нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбайн дунджийг гаргахад 287.5 кв буюу 28 үйлчлэгчийн орон тоотой гарч байна.

¹ Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

НХХЯ-ны сайдын 2001 оны 03 дугаар тушаалаар батлагдсан “Нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбай, ажлын үлгэрчилсэн хэмжээ”-нд тусгагдсаны дагуу үйлдвэр үйлчилгээний газар гэхэд модон, дубэн, алаг чулуун, хулдаасан гэж 4 хэсэгт хувааж цэвэрлэх талбайн хэмжээг заасан байхад үйлчлэгчийн цэвэрлэх талбайг нарийн тооцож төлөвлөөгүй нэг үзүүлэлтээр төлөвлөж тооцсон байна.

Цаашид эмнэлгийн хүний нөөц, орон тоог нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллуулах шаардлага үүсэж байна.

А.1.3 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн 2020 оны судалгаагаар 230.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж шаардагдсанаас 18.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж ажилласан байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн 2020 оны эд хөрөнгийн тооллогоор тасаг тус бүрээр хийсэн эд хогшил, хөрөнгийн тооллогын эцсийн үлдэгдлээр 4.9 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг тоолж бүртгэсэн байна.

Үүнээс 2020 онд худалдаж авсан болон ОНХС, ЭМЯ, аж ахуй нэгжээс үнэ төлбөргүй болон хандив тусламжаар нийт 253.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлжээ.

Хандив тусламжийн хөрөнгийг хүснэгт №1, дутагдаж байгаа тоног төхөөрөмжийг хүснэгт №2 харуулбал:

Нэгдсэн эмнэлэгт 2020 онд худалдаж авсан болон төсөл хөтөлбөр, хандив тусламжаар орлогот авсан машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын жагсаалт
/хүснэгт №1/

№	Хөрөнгийн нэр	Нэг бүрийн үнэ	х/н	Тоо	Дүн	Мөнгөн дүн	Нийлүүлэгч
Машин тоног төхөөрөмж худалдаж авсан							
1	Өвчтөн зөөвөрлөх ор /каталка/	790,0	ш	1	790,0	3,740,0	Нуган трейд ХХК
2	Өвчтөний функциональ ор	650,0	ш	2	1,300,0		
3	Яаралтай тусламжийн тэргэнцэр	1,650,0	ш	1	1,650,0		
4	Нярайн дулаацуулагч	2,700,0	ш	3	8,100,0	11,020,0	Нуган трейд ХХК
5	Сорох төхөөрөмж	440,0	ш	3	1,320,0		
6	Хүчил төрөгч өтгөрүүлэгч /зөөврийн/	800,0	ш	2	1,600,0		
7	Компьютер сервер	3,500,0	ш	1	3,500,0	3,500,0	Орхон электроникс ХХК
8	Тэргэнцэр /сувилагчийн/	270,0	ш	2	540,0	12,620,0	Монос булган ХХК
9	Тэргэнцэр /сувилагчийн/	280,0	ш	3	840,0		
10	Тэргэнцэр /сувилагчийн/	320,0	ш	3	960,0		
11	Тэргэнцэр /цэвэрлэгээний/	350,0	ш	10	3,500,0		
12	Тэргэнцэр /сувилагчийн/	280,0	ш	1	280,0		
13	Д-г тодорхойлох аппарат	6,500,0	ш	1	6,500,0		
14	Процессор /9 үе i5/	1,503,5	ш	3	4,510,5	4,510,5	БСБ Коммерс ХХК
15	Дэлгэц	300,0	ш	1	300,0	300,0	ВІТС ХХК
	МТТ Дүн				35,690,5		
Машин тоног төхөөрөмж ОНХСан							

Аймгийн нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар хүртээмжийн үр дүн

1	Принтер samsung M-2070	349,2	ш	1	349,2	349,2	БСБ Коммерс ХХК
2	Тариурын автомат шахуурга	1,350,0	ш	1	1,350,0	2,800,0	СОБЦ ХХК
3	Тэргэнцэр багажны	1,450,0	ш	1	1,450,0		
	МТТ Дүн				3,149,2		
Машин тоног төхөөрөмж ЭМЯ-аас үнэ төлбөргүй							
1	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч	1,470,0	ш	1	1,470,0	1,470,0	Медимпекс интернейшнл
2	Амьсгалын аппарат	34,900,0	ш	1	34,900,0	34,900,0	Интер сайнс ХХК
3	Genexperet аппарат	30,650,4	ш	1	30,650,4	32,500,4	МЭИК-ЭМЯ Глобаль сан
4	Дэлгэц DELL	350,0	ш	1	350,0		
5	Компьютер	1,500,0	ш	1	1,500,0		
6	Дэлгэц /рентгэн аппаратны/	51,939,8	ш	1	51,939,8	99,300,0	Си Ай Ти ХХК
7	Зөөврийн рентген апарат	44,860,1	ш	1	44,860,1		
8	Нөөтбүк /рентгэнны/	2,500,0	ш	1	2,500,0		
9	Термостат	1,333,3	ш	1	1,333,3	1,333,3	ХӨСҮТөв
10	Дуслын аватомат шахуурга	1,633,0	ш	1	1,633,0	5,442,0	ЭМГазар
11	Хяналтын монитор	3,809,0	ш	1	3,809,0		
12	Хяналтын монитор	3,809,0	ш	1	3,809,0	7,618,0	Биомед трейд ХХК /ЭМГ/
13	Хяналтын монитор	3,809,0	ш	1	3,809,0		
14	Өвчтөний функциональ ор	9,042,0	ш	1	9,042,0	9,042,0	Чоногол трейд ХХК
15	Иммунологийн анализатор	8,030,0	ш	1	8,030,0	14,235,3	Улсын гуравдугаар төв эмнэлэг /люксембург/
16	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	3,105,3	ш	1	3,105,3		
17	Даралтын аппарат /суурин/	3,100,0	ш	1	3,100,0		
	МТТ Дүн				205,841,03		
ААН Хандив							
1	Монитор	3,376,2	ш	1	3,376,2	6,752,4	Мобиком ХХК,
2	Монитор /хүүхдийн/	3,376,2	ш	1	3,376,2		
3	Компьютер	1,500,0	ш	1	1,500,0	1,800,0	БУЛГАН ХААН БАНК
4	Принтер	300,0	ш	1	300,0		
	Дүн				8,552,4		
	МТТ Дүн				253,233,1		

Булган аймгийн НЭ-т 2020 онд шаардлагатай, дутагдаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн жагсаалт

/хүснэгт №2/

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ	Тайлбар
1	Уян дурангийн тоног төхөөрөмж	1	50000.0	50000.0	MNS5095:2017 стандартын В хавсралт
2	Дуран хатаах шүүгээ	1	5000.0	5000.0	MNS5095:2017 стандартын В хавсралт
3	Флюорографийн аппарат	1	25000.0	25000.0	MNS5095:2017 стандартын В хавсралт
4	Суурин угаалгын автомат аппарат /угаах, зайлах, мушгих, хатаах горимоор ажиллах/	1	15000.0	15000.0	MNS5095:2017 стандартын В хавсралт

Аймгийн нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар хүртээмжийн үр дүн

5	Индүүдлэг хийх зориулалтын бултай суурин аппарат	1	10000.0	10000.0	MNS5095:2017 стандартын В хавсралт
6	Яаралтай тусламж, сэхээн амьдруулахын суурь тусламжийн иж бүрдэл	1	15000.0	15000.0	MNS5095:2017 стандартын В хавсралт Хүлээн авахад ашиглах
7	Монитор	5	5000.0	25000.0	Тасаг нэгжүүдэд нэмэгдүүлэх шаардлагатай байна
8	Пульсоксиметр	10	500.0	5000.00	Тасаг нэгжүүдэд нэмэгдүүлэх шаардлагатай байна
9	Тархины судасны доплер	1	50000.0	50000.0	Мэдрэлийн тасгийн оношилгоонд ашиглах
10	Нярайн зөөврийн амьсгалын аппарат	1	25000.0	25000.0	Хүүхэд нярайн яаралтай тусламжийн чанарыг дээшлүүлэх
11	Зориулалтын эд эс хөлдөөгч	1	2000.0	2000.0	MNS5095:2017 стандартын В хавсралт Эмгэг судлалд ашиглах
12	Будагч аппарат	1	3000.0	3000.0	MNS5095:2017 стандартын В хавсралт Эмгэг судлалд ашиглах
Нийт дүн				230000.0	

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2020 онд 230.0 сая төгрөгийн дутагдалтай хөрөнгийн жагсаалт бэлтгэн ажилласнаас тухайн онд 18.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бэлтгэн нийлүүлж бүртгэн авч холбогдох тасгуудад хуваарилан өгчээ.

Үүнээс 211.8 сая төгрөгийн дутагдалтай тоног төхөөрөмжийг дээд газартаа хүсэлт гаргасан эсэх нь тодорхойгүй байгаа тул аймгийн Засаг дарга, ЭМГ-т Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь ² заалтуудыг хангах зөвлөмж өгч ажиллалаа.

А.2 Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээний бэлэн байдлыг хууль, дүрмийг үндэслэн тушаал шийдвэрийн дагуу холбогдох журмуудыг батлан гаргасан байна.

А.2.1 Яаралтай түргэн тусламж үйлчилгээний болон дуудлагаар ажиллах эмнэлгийн холбогдох журмуудыг байгууллагын даргын тушаалаар батлан мөрдлөг болгон ажиллажээ.

Нэгдсэн эмнэлэг нь 2020 онд эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, ЭМС-ын 297, 263 дугаар тушаалаар тус тус баталсан “Журам батлах тухай”, “Алсын түргэн тусламжийн дуудлагын зохицуулах журам” зэргийг үндэслэн “Түргэн тусламжийн ажиллах журам”, “Алсын түргэн тусламжийн дуудлагын үйлчилгээг зохицуулах журам”, “Хүлээн авах яаралтай тусламжийн тасгаас өвчтөн шилжүүлэх журам”-уудыг тус тус хавсралтаар баталж ажиллажээ.

Дээрх журмуудад тусгагдсаны дагуу хүлээн авах яаралтай тусламжийн тасаг, алсын дуудлагын үйлчилгээ зэргийн тавигдах шаардлага болон талбар дээрх ажилтай танилцах, бодит байдалд дүгнэлт хийх ажлууд ковид-19, цар тахалтай холбогдуулан хийгдээгүй, цахим хаягаар нөхцөл байдлын зургийг холбогдох ажилтнаар авч баталгаажуулж ажилласан.

Үүнийг зургаар илэрхийлбэл:

² Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлж, олсон орлогыг эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, засвар, үйлчилгээ хийхэд зарцуулах бөгөөд уг орлогыг зарцуулах үлгэрчилсэн журмыг санхүүгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.



Дээрх зургаас үзэхэд түргэн тусламжийн бэлэн байдал болон эмийн зарцуулалт бүртгэлийг хөтөлж, ажил хэвийн явагдаж байгаа боловч дэлхий нийтийг хамарсан цар тахлын үед хүндрэл үүсэж байгаа нь харагдаж байна.

А.2.2 Яаралтай түргэн тусламж үзүүлэхэд шаардлагатай эм, багаж хэрэгслийн, автомашин, тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, дуудлагын бүртгэл, жолоочийн тооцооны замын хуудас шатахууны тооцоог бүрэн хөтөлдөг ч түргэн тусламжийн дуудлагын бүртгэлийг дутуу хөтөлсөн, холбогдох журмуудыг мөрдлөг болгож ажиллаагүй байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2020 оны түргэн тусламжийн алсын болон дотор дуудлагын бэлэн байдал, дуудлагын бүртгэл хөтлөлт, шатахуун зарцуулалт, жолоочийн тооцооны замын хуудас зэргийн анхан шатны баримтад тулгуурлан түүвэрлэлтээр шалгахад түргэн тусламжийн дуудлагын хуудсаар бүртгэл хөтөлж тус бүртгэлээр ямар эмч, жолооч дуудлага өгснөөс хойш хэдэн минутад явсан, буцсан, өвчтөний биеийн байдал, яаралтай, яаралтай бус дуудлага зэргийг тэмдэглэл хөтөлж ажилласан байна.

Түргэн тусламжийн дуудлагын тэмдэглэлээр зарим алсын болон дотор дуудлагын хуудсанд эмч, жолооч, машины марк, дугаарыг дутуу бичсэн, ямар эмч, жолооч, ямар машинтай явсныг тодорхой бичиж хөтлөөгүй байна.

Жишээ нь: Дотор дуудлагын 2020 оны 7 дугаар сарын 09, 12, 18, 28, 30, 10 дугаар сарын 04, 05, 08, 11 дүгээр сарын 02, 03, 06, 08, 12 дугаар сарын 09, 20-ны өдрүүдийн, алсын дуудлагын 01 сарын 07, 16, 28, 2 сарын 27, 05 дугаар сарын 12, 7 дугаар сарын 11, 9 дүгээр сарын 23-ны өдрүүдийн дуудлагын бүртгэлийг дутуу хөтөлсөн, мөн алсын дуудлагын нийт 206 дуудлагаас 20 дуудлага журамд заасан хугацаанаас хойш дуудлагаар гарсан зөрчлүүд илэрсэн нь Нэгдсэн эмнэлгийн даргын 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/27 тоот тушаалын хавсралтаар баталсан “Нэгдсэн эмнэлгийн түргэн тусламжийн ажиллах журам”-ын 6 дахь³, “Алсын түргэн тусламжийн дуудлагын үйлчилгээг зохицуулах журам”-ын 17 дахь⁴ гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тухайн онд нийт 45464.2 мянган төгрөгийн шатахуун зарцуулснаас алсын дуудлагын 76666 км-т 268 л шатахууны 24951.0, дотор дуудлагын 28825 км-т 5134 л шатахууны 8878.9 мянган төгрөгийн нийт 33829.9 мянган төгрөгийн шатахуун зарцуулж ажилласан нь жилийн зарцуулсан шатахууны 74.4 хувийг эзэлж байна.

Цаашид түргэн тусламжийн дуудлагын жижүүр эмч нарт алсын болон дотор дуудлагын бүртгэлийг бүрэн хөтөлж холбогдох хууль, журмын дагуу хариуцлагыг тооцож ажиллах шаардлагатай байна.

А.3 Хоол хүнсний хангалт, нийлүүлэлт эрүүл ахуйн шаардлага бүрэн хангаагүй байна.

А.3.1 Эмнэлгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ нь хэвтэн эмчлүүлэгчдэд норм нормативын дагуу хүрч ажиллаж байгаа ч 56218.9 мянган төгрөгийн мах, махан бүтээгдэхүүнийг гэрээ байгуулаагүй худалдан авалт хийжээ.

Нэгдсэн эмнэлгийн хоол хүнсний материал нийлүүлэх, худалдан авах ажиллагааны тендер зарласан боловч үнийн санал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулсан байна.

Үүнд:

- ✓ “Хүрэн дэнж агро” ХХК хүнсний ногоо, жимс жимсгэнэ 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

³ Дуудлагын эмч нь түргэн тусламжийн хуудас, зөвшөөрөгдсөн бүртгэл, хяналтын хууднуудыг бүрэн хөтөлсөн байна.

⁴ Алсын дуудлагын багийг томилогдсоноос хойш 30 минутын дотор бэлэн болгож гаргаагүй бол тухайн өдрийн дуудлага хүлээн авсан сувилагч нарт холбогдох хууль, тогтоомж байгууллагын дотоод журмыг үндэслэн урамшуулал, хариуцлагын арга хэмжээг тооцно.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар хүртээмжийн үр дүн

- ✓ Жавхлант гартаам ХХК угаалга цэвэрлэгээний материал 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
- ✓ Халиун тариа ХХК сүү, сүүн бүтээгдэхүүн 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл тус тус гэрээ байгуулсан боловч 56218.9 мянган төгрөгийн мах, махан бүтээгдэхүүнийг гэрээ байгуулаагүй, тендерийн багцад оруулж тендер зарлаагүй зэрэг зөрчил илэрсэнд албан шаардлага бичлээ.

Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2020 оны хоол хүнсний зарцуулалтаар нярваас 41.3 мянган хүнд 114.3 сая төгрөгийн хүнсний материал олгосноос гал тогооноос хэвтэн эмчлүүлэгч 38.7 мянган хүнд 110.06 сая төгрөгийн хүнс зарцуулж жилийн эцсийн үлдэгдэл няравт 14.3, гал тогоонд 0.6 мянган төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй байна.

Хүнсний орлого, зарлагыг хүснэгтээр харуулбал:

Нэгдсэн эмнэлгийн хоол хүнсний жилийн эцсийн үлдэгдэл

№	Хүнсний материал	Эхний үлдэгдэл		Орлого		Зарлага		Эцсийн үлдэгдэл	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нярав	1943	4819.5	4522	10969.0	4209	11420.9	2257	4367.6
	Гал тогоо	31	72.4	3910	10790.2	3871	10456.6	69	406.0
2	Нярав	2257	4367.6	3744	9864.6	3226	8593.6	2775	5638.5
	Гал тогоо	69	406.08	2916	8355.2	2923	8442.1	62	319.1
3	Нярав	2775	5638.5	3637	11181.6	3490	10569.4	2922	6250.7
	Гал тогоо	62	319.1	3387	10353.1	3368	10164.2	81	508.0
4	Нярав	2922	6250.7	4491	11996.8	3885	10681.06	3528	7566.4
	Гал тогоо	81	508.05	3290	10347.5	3238	9908.1	133	947.4
5	Нярав	3528	7566.4	2728	8716.8	3330	9763.08	2926	6520.2
	Гал тогоо	133	947.5	3246	9586.1	3323	10198.7	55	334.8
6	Нярав	2926	6520.2	2842	7794.2	3344	10031.1	2423	4283.3
	Гал тогоо	55	334.8	3202	9483.9	3226	9649.2	31	169.6
7	Нярав	2423	4283.3	3157	10828.9	3304	9715.4	2276	5396.7
	Гал тогоо	31	169.6	3231	9560.5	3226	9475.4	36	254.7
8	Нярав	2276	5396.7	2933	7273.9	2631	7689.0	2578	4981.6
	Гал тогоо	36	254.7	2531	7318.6	2499	7194.6	67	378.6
9	Нярав	2578	4981.6	3571	7722.5	2643	6965.5	3505	5738.6
	Гал тогоо	67	378.6	2548	6766.0	2507	6527.5	109	617.2
10	Нярав	3505	5738.6	2481	7154.0	3716	8224.7	2270	4667.8
	Гал тогоо	109	617.2	3081	7908.7	3165	8370.4	25	155.4
11	Нярав	2270	4667.8	5029	11239.0	3661	9031.2	3638	6875.6
	Гал тогоо	25	155.4	3306	8775.1	3242	8333.2	89	597.4
12	Нярав	3638	6875.6	4745	19135.7	4292	11657.1	4091	14354.2
	Гал тогоо	89	597.4	4196	11435.7	4181	11346.0	104	687.1

А.3.2 ТБОНӨБАҮХАТ хуулийг зөрчин Нэгдсэн эмнэлгийн хоол хүнсний материалыг шууд гэрээ байгуулан бэлтгэн нийлүүлж ажиллажээ.

Нэгдсэн эмнэлэг нь 2020 онд өвчтөний хоолны зардалд 124,851.2 мянган төгрөг батлагдсанаас, гүйцэтгэлээр 124,862.6 мянган төгрөгийг зарцуулж 11.4 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулжээ.

НЭ-ийн хүнсний материал нийлүүлэх худалдан авах ажиллагааг НЭ-ийн даргын 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/31 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороо байгуулж “Хүнсний материал нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэх урилга”-ыг 2020 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр 4 багц нийт 42892.2 мянган төгрөгийн нээлттэй тендер зарлаж Үндэсний шуудан сонин болон цахимаар зар тавьсан боловч тендерт оролцох тендерийн материал ирүүлээгүй байна.

БУА-2021/06-ШТА-ГА

Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2⁵ дахь заалт, Засгийн газрын “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 2013 оны 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй тендер худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, 3 бэлтгэн нийлүүлэгчтэй 51,259.5 мянган төгрөгөөр шууд гэрээ байгуулан, 73,927.2 мянган төгрөгийн хүнсний материалыг гэрээгүй, тендер сонгон шалгаруулалтгүйгээр бэлтгэсэн байна.

Аймгийн Мал эмнэлгийн газарт НЭ-ийн бэлтгэн нийлүүлсэн мах, сүү цагаан идээг шинжилгээнд хамрагдсан эсэхийг нягтлан шалгахад Нэгдсэн эмнэлэгт 2020 онд 5 бэлтгэн нийлүүлэгчээс бусад бэлтгэн нийлүүлэгч нь шинжилгээний бичиггүй, мал эмнэлгийн гэрчилгээ буюу гарал үүслийн бичгээр гүйлгээ хийгдсэн, бэлтгэн нийлүүлсэн махыг зарцуулсны дараа шинжилгээнд хамруулсан зэрэг зөрчил илэрч байгаа нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй эрсдэлийг дагуулж байна.

А.4 Төлбөртэй үйлчилгээний орлого бүрдүүлэлт хангалттай байна.

А.4.1 Төлбөртэй тусламж үйлчилгээний орлогыг өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан төсөвт батлуулж ЭМДС-гаас 3585 хэвтэн эмчлүүлэгчийн 1083.1 сая төгрөгийн санхүүжилт авчээ.

Төлбөртэй тусламж үйлчилгээний орлогыг өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан 2020 оны төсөвт төлөвлөж, гүйцэтгэлийг тооцож ажилласан байна.

Эрүүл мэндийн даатгуулагч иргэнд үзүүлэх тусламж үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг Нэгдсэн эмнэлгийн даргын 2020 оны А/04 дугаар тушаалаар шинэчлэн баталж, мөрдөж ажиллаж байна.

2020 онд ор хоногийн төлбөр 1190 хэвтэн эмчлүүлэгсдээс 42,298.6 мянган төгрөг, тусламж үйлчилгээний төлбөр 1818 өвчтөнөөс 40,312.9 мянган төгрөг нийт 82,611.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэн төвлөрүүлжээ.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2020 онд нэгдсэн эмнэлэг ЭМД-ийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний 7 төрлийн санхүүжилт олгож байна. Үүнд:

1. Оношилгоо, үйлчилгээ
2. Хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ
3. Уламжлалт эмчилгээ
4. Өдрөөр эмчлэх тусламж үйлчилгээ
5. Хөнгөвчлөх үйлчилгээ
6. Амбулаторийн үйлчилгээ
7. Урьдчилан сэргийлэх багцын үзлэг хамрагдаж байна.


Дээрх 7 төрлийн төлбөртэй тусламж үйлчилгээний хувьд дараах зөрчлүүд илэрч байна. Үүнд:

- Хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээний хувьд ЭМДС-д нэхэмжлэх өгч авсан санхүүжилтийн 3585 хэвтэн эмчлүүлэгчийн 1083.1 сая төгрөгийн санхүүжилт авчээ.
- Нэгдсэн эмнэлгийн статистик мэдээгээр үр хөндөлт 68 байхад, үр хөндөлтийн төлбөрт үйлчилгээний орлого байхгүй, эмчийн заалттай хийгдсэн үр хөндөлтийн бүртгэл байхгүй байна.

2020 онд хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 4733, ор хоног 34442 болж өмнөх оноос хэвтэн эмчлүүлэгчийн тоо 425, ор хоног 4402-оор буурсан үзүүлэлттэй байгаа нь Ковид-19 цар тахалтай холбоотой эмнэлгээр үйлчлүүлэх иргэдийн тоо буурсан байна.

Мөн “Нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн үр дүн”-д хийж буй гүйцэтгэлийн аудитаар иргэд олон нийтээс санал авахаар 12 асуулгыг бэлтгэн цахимаар санал авахад 86 иргэн судалгаанд хамрагдаж үүнийг дүгнэхэд иргэний саналаас эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээ мэдээллийг иргэдэд хангалтгүй хүргэдэг, эмч сувилагчийн иргэдтэй харилцах харилцааны соёл муу, нарийн мэргэжлийн эмч дутмаг, иргэд нэгдсэн эмнэлгээр үйлчлүүлэхэд хувиасаа эм тариа авч үйлчилгээ авсан ч буцааж эм тарианы мөнгөө авч чаддаггүй, ЭМДС-гаас төлбөрийг нь хариуцдаг тусламж үйлчилгээнд иргэд сэтгэл хангалуун байж чадахгүй зэрэг үр дүн гарсан талаарх асуудлыг графикаар хувьчилж харуулбал:

⁵ шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар,



Эмнэлгийн тусламж үйлчилгээг 34.1 хувь нь найз нөхөд, танил хүмүүсээс авдаг бол 58.1 хувь нь эмчийн харилцааны соёлгүй асуудалтай тулгардаг байна.

Мөн үйлчилгээ авахад хувиасаа эм тарианы мөнгөө гаргаж буцааж аваагүй 66.3 хувь, ЭМДС-аас төлбөрийг нь гаргадаг тусламж үйлчилгээнд сэтгэл хангалуун бус 58.1 хувийн хариултаар үр дүн гарч байна.

Иймд эмнэлгийн эмч ажилчдын харилцаанд анхаарч ажиллах нь судалгаагаар харагдаж байна.

А.4.2 Төлбөртэй тусламж үйлчилгээний 82611.5 мянган төгрөгийн орлогоор санхүүжсэнээр статистик мэдээг тайлагнажээ.

Нэгдсэн эмнэлгийн 2020 онд ЭМДС-гаас ор хоног болон төлбөртэй үйлчилгээний орлого санхүүжилтийн дүнг статистик мэдээний дүнгээс үзэхэд нийт 3008 хүний 82611.5 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого авч ажилласнаар мэдээлсэн байна.

Үүнийг тасаг тус бүрээр мөн бусад үйлчилгээний орлогын дүнтэй тулгахад ЭМД-ын тасгаас холбогдох баримт материалыг аудитын материалын шаардах хуудсаар 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн дотор нэр бүхий 13 төрлийн аудитын материал шаардсан боловч аудитын хугацаанд холбогдох баримт материалыг ирүүлээгүй тул Эрүүл мэндийн даатгалын тасгийн мэргэжилтэн Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1⁶ дэх заалтын дагуу аудитын үйл ажиллагаанд саад учруулж, аудитын баримт материалыг гаргаж ирүүлээгүй тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах саналыг хүргүүлж байна.

А.5 Аюултай хог хаягдлыг устгах үйл ажиллагаа хууль журмын дагуу зохион байгуулагджээ.

А.5.1 Эмнэлгийн аюултай хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгахад холбогдох дүрэм, журмыг мөрдөж байгаа ч хяналтын байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлсэн байна.

Нэгдсэн эмнэлгийн хог хаягдлын ангилал, бүртгэл, устгалыг үзэхэд ЭМС-ын 2019 оны 537 дугаар тушаалаар баталсан Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах зааврын дагуу хог хаягдлыг ахуйн, халдварт, эмийн гаралтай, эмгэг хог хаягдал гэж 4 хэсэгт хуваан тэмдэг тэмдэглэгээ хийж

⁶ Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

Аймгийн нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар хүртээмжийн үр дүн

ангиан хог хаягдлыг халдвартай хог хаягдал, хурц үзүүртэй, иртэй, эмгэг хог хаягдал, цацраг идэвхт, эмийн болон эсэд хортой хог хаягдлууд гарснаар бүртгэл хөтөлсөн байна.

Хог хаягдлын байр, болон хогийн савны ангиллыг зургаар харуулбал:



Хог хаягдал бүртгэн хүлээн авах байр



эмгэг хог хаягдал



гадна хогийн сав



халдварт хог хаягдал



ахуйн хог хаягдал



Тус байгууллага нь хог хаягдлыг ЭМС-ын тушаалаар баталсан заавар журмын дагуу устгалыг хийж байгаа ч бодит байдал болон зургаас харахад хог хаягдлын савны хүрэлцээ хангалтгүй, хогийн сав дүүрсэн байдалтай, мөн МХГ-аас өгсөн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 06-03-011/192 тоот “Зөрчил арилгуулах тухай” албан шаардлагын дагуу ажиллаагүй байна.

Албан шаардлагад ахуйн хогийн савны багтаамж бага, хүрэлцээ муу, хогоо ил задгай хаяхгүй, гадна талбайд 30 м тутамд хогийн сав байрлуулах зэрэг зөвлөмж хүргүүлж ажилласан ч өнөөгийн байдалд уг зөрчил арилаагүй хэвээр байна.

Мөн хогийг цаг тухайд нь зайлуулаагүй, хогийн савны хүрэлцээ муу байгаа, эмгэг хогны битүүмжилсэн нүхийг дүүрэх болгонд нь шинээр нүх ухаж шинэчилж байгаа нь цаашлаад хөрсний бохирдол үүсгэх, эрүүл ахуйд нөлөөлж болзошгүй байна.

Иймд хогийн савны багтаамж, хүрэлцээг аль болох нэмэх, цаг тухайд нь хогийг ачуулж устгалыг хийж ажиллахад хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Б. Нэгдсэн эмнэлгийн дотоод хяналтын баг нь тухайн жил хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулан ажиллаагүй байна.

Б.1 Эмийн зарцуулалт тавих шат шатны хяналт сул байна.

Б.1.1 Эмнэлэгт хэрэглэгдэх эмийн жагсаалтыг жил бүр гарган, хэрэгцээний зэрэглэлээр ангилах, эмийн эмчилгээг зохицуулах хороог байгуулан ажиллажээ.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг Эмийн эмчилгээг зохицуулах хорооны журмын дагуу Нэгдсэн эмнэлгийн даргын 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/07 тоот тушаалаар эмийн эмчилгээг зохицуулах хороо, антибиотикийн дэд хороо, нянгийн эсрэг эмийн жагсаалт, антибиотик хэрэглэх журам, тасаг нэгжүүдэд хэрэглэгдэх яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт, Олон улсын хөл хориотой өвчний үед хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг тус тус баталсан нь Эмийн зохицуулах хорооны журмын дагуу тушаал гарган ажиллажээ.

Үүний хүрээнд Нэгдсэн эмнэлгийн эмийн зохицуулах хороо нь 2020 онд 5 зорилтын хүрээнд 28 ажил хийхээр төлөвлөн Нэгдсэн эмнэлгийн даргаар 2020 оны 01 дүгээр сарын

05-ны өдөр батлуулан ажиллаж 4 ажил нь бүрэн хийгдэж “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төлөө” хүүхдийн тасагтай хамтарч хийх аян явагдаагүйгээс хэрэгжилт 97.3 хувийн биелэлттэй гарсан байна.

Б.1.2 Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, хэрэглээ, хадгалалт, хамгаалалт зарцуулалтад хяналт тавьж ажиллаж байгаа ч зарим тасгийн эмийн зарцуулалтын тайлан илүү, дутуу зөрүүтэй тайланагдаж байна.

Нэгдсэн эмнэлэг нь тайлант онд 999928.2 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авч, хандиваар 122705.6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл ирж нийт 1122633.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлж, 1007322.2 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл зарцуулж 190790.7 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн үлдэгдэлтэй, 103949.3 мянган төгрөгийн эмийн өртэй тайлагнажээ.

Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх тендер зохион байгуулалтыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/45 тоот тушаалаар 2020 онд үзүүлэх тусламж үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийн шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулж эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгчийн сонгон шалгаруулалтыг 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр цахимаар нээлттэй зарлаж, 2020 оны 02 сарын 10-нд нээснээс сонгон шалгаруулалтад нийт 27 компани 28 багцад 73 материал ирүүлснээс нэгдсэн эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх нийлүүлэгчээр ТБОНӨХБАҮХАТ хуулийн 28.7.3, 28.7.5 дахь заалтуудыг үндэслэн 14 компани шалгарч гэрээ байгуулах эрх олгосон байна.

Эмийн тендерийн санал ирүүлээгүй 20, 22, 23, 28 дугаар багцын тендер шалгаруулалтыг 2020 оны 03 дугаар сарын 09-ны өдрөөс 04 дүгээр сарын 09-ний хооронд дахин зарлаж 20, 22, 23 дугаар багц дээр 4 компани материал ирүүлснээс ТБОНӨХБАҮХАТ хуулийн 28.7.5, 30.10.1 дахь заалтуудыг үндэслэн 2 компани шалгаруулж гэрээ байгуулах эрх олгож, 28 дугаар багцад санал ирүүлээгүй тул ТБОНӨХБАҮХАТ хуулийн 36.18 дахь заалтыг үндэслэн хуучин харилцагч байгууллагатай шууд гэрээ байгуулахаар шийдвэрлэж эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэхдээ нийт 44 байгууллага аж ахуйн нэгжээс худалдан авалт хийж үүний 17 компани нь тендерт шалгарч гэрээ байгуулсан, нэмж 10 компанитай гэрээ байгуулан бусад 17 компани болон хувь хүнээс 3777.7 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгслийн туслах хэрэгслүүдийг гэрээ байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн нь нийт худалдан авалтын 0.3 хувийг эзэлж байна.

Нэгдсэн эмнэлгийн эмийн зарцуулалтын тайлангаас түүвэрлэлт хийж дотрын тасгийн 2, 3, мэдрэлийн тасгийн 7, 8 дугаар саруудын эмийн зарцуулалтын тайлан, тухайн саруудад эмнэлэгт хэвтсэн өвчний түүхээр зарлагадсан эмийн нэгтгэлд тулгалт хийхэд дотрын тасгийн эмийн зарцуулалтаас 686 ширхэг 1203.8 мянган төгрөгийн эм дутаж, 690 ширхэг 477.6 мянган төгрөгийн эм илүү, мэдрэлийн тасгийн эмийн зарцуулалтаас 804 ширхэг 433.0 мянган төгрөгийн эм дутаж, 384 ширхэг 231.9 мянган төгрөгийн эм илүү, нийт 2346.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд албан шаардлага бичлээ.

Дээрх зөрчил нь ээлжийн сувилагч нар өвчний түүх дээр эм зарлагдахдаа дутуу, эмийн үнийг буруу бичдэг, хувь хүний өөрөө авсан болон эмнэлгээс олгосон эмийн тэмдэглэгээг бүрэн хийдэггүй, тайланд үеэс өмнө авч хэрэглэсэн эмийн өрийг дутуу суутгадаг, тасгийн эмийн тайланг гаргадаг ахлах сувилагч өөрийн эрхлэх ажил биш гэж хайнга ханддаг зэргээс шалтгаалж зөрүү гарч байна.

Цаашид тасаг бүр өвчний түүх дээрх эмийн зарлагыг зөв тооцож гаргах, тухайн тайлант үеийн эмийн үнийг зөв бичих тасгийн эмийн тайланг үнэн зөв гаргаж сайжруулах шаардлагатай байна.

Б.2 Чанарын хяналтын багийн гишүүд хяналт шалгалт хийсэн тохиолдол бүрд дүн шинжилгээ хийж, оновчтой сургалт зохион байгуулбал байгууллагын үйл ажиллагаа, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн баталгаа нэмэгдэх бололцоотой нь харагдаж байна.

Б.2.1 Байгууллагын дотоод хяналт шалгалтын баг, жилийн ажлын төлөвлөгөө батлуулаагүй, нэг удаагийн сарын аяны ажлаас өөр хяналт шалгалт зохион байгуулаагүй байна.

Нэгдсэн эмнэлгийн дотоод хяналт шалгалтын багийг 2019 оны 09 дүгээр сарын А/36 дугаар тушаалаар 12 хүнийг 4 баг болгон 14 тасгийг хуваан дотоод хяналтыг хийхээр баталсан байна.

Дотоод хяналт шалгалтын баг нь жилийн ажлын төлөвлөгөө батлаагүй, тухай бүр нь удирдамж гарган төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байгаа нь байгууллагын дотоод хяналт шалгалтын багийн ажиллах журмын 3.1 дэх⁷ гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Дотоод хяналт шалгалтын баг нь 2020 оны 05 дугаар сард “Төрийн албан хэрэг хөтлөлт, хүний нөөцийн хангалтыг дээшлүүлэх” чиглэлээр сарын аян зарлан 2020 оны 05 дугаар сарын 05-21-ний хооронд хийж гүйцэтгэхээр удирдамж төлөвлөгөө гаргаснаас өөр хяналт шалгалт хийгээгүй байна.

Шалгалт хийсэн тухай 4 багийн тайлан, илтгэх хуудас байхгүйгээр төлөвлөгөөний биелэлт гаргасан байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал, өгсөн дүгнэлт, зөвлөмж түүний хэрэгжилт зэрэг баримт материал дутуу байна.

Дотоод хяналт шалгалтын багийн 2020 онд хийсэн нэг удаагийн сарын аяны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудад байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд бодит нөлөө үзүүлэхүйц дорвитой хяналт шалгалтын ажил тусгагдаагүй байна.

2020 онд баг бүр нэг удаагийн хяналт шалгалтыг хийсэн нь журмын 3.2 дахь “Дотоодын хяналт шалгалтын баг нь төлөвлөгөөний дагуу байгууллагын удирдлагаар батлуулсан удирдамжаар хяналт шалгалт хийж, ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа байгууллагын удирдлагад танилцуулж, шаардлагатай тохиолдолд холбогдох шийдвэрийг гаргуулан хамт олонд мэдээлэх.” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Байгууллагын дотоод хяналт шалгалт нь үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиглэлд тодорхой үр дүнтэй шалгалт зохион байгуулж биелэлтийг тооцож ажиллах шаардлагатай байна.

Б.2.2 Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгаж байгаа хэдий ч өгсөн зөвлөмж, алдаа зөрчлийн биелэлтийг тооцдог, давтан шалгалтыг хийдэг байх шаардлага үүсэж байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дүрэм, бүрэлдэхүүнийг 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 тушаалаар баталсан байна.

Бүрэлдэхүүнд орон тооны 2, орон тооны бус 6 гишүүнтэй, 13 тасаг нэгжийн ЭМТҮЧАБ-ын багийг тасгийн эрхлэгч их эмч ахалж, тасгийн ахлах сувилагч гэсэн 3 ажилтантай чанар аюулгүй байдлыг хариуцан ажиллахаар хавсралтаар баталжээ.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба нь 2020 онд “Эелдэг харилцааг төлөвшүүлэн тусламж үйлчилгээний эрсдэлийг бууруулж, аюулгүй байдлыг хангах” гэсэн зорилго дэвшүүлэн дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллажээ. Үүнд:

1. Чанарын удирдлага зохион байгуулалт
2. Хүний нөөцийн чадавхыг сайжруулах
3. Чанар сайжруулах үйл ажиллагааны төлөвлөлт хэрэгжилт
4. Чанарын хяналт үнэлгээ
5. Эрсдэл бууруулж, аюулгүй байдлыг хангах талаар:
6. Хөндлөнгийн аудитын зөвлөмжөөр гэсэн 6 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлж 90 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр “Эмнэлгийн анхан шатны бүртгэлийг сайжруулах”, “Антибиотикийг жорын дагуу хэрэглэе АБ даслаас урьдчилан сэргийлье”, “Эмчилгээний эхлэл эерэг хандлага” зэрэг 3 аяныг зохион байгуулсан байна.

Мөн эмнэлгийн ажилчдын дотоод сургалтыг 132 сэдвийн хүрээнд давхардсан тоогоор 2935 хүнд сургалт зохион байгуулж, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг 48 сэдвийн хүрээнд 19602 хүнд хийгдэж чанарын хяналтыг 23 удаа хийж дундаж үнэлгээ 83 хувьтай гарчээ. Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/566 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах журам”-ын дагуу чанарын багууд 2020 онд дараах тохиолдлыг бүртгэжээ. Үүнд: Үйлчлүүлэгчийн танин тодруулгатай холбоотой 2, харилцааны дутагдал доголдолтой холбоотой 3, эмийн аюулгүй байдалтай холбоотой 2, мэс заслын аюулгүй байдалтай

⁷ Дотоод хяналт шалгалтын баг нь тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг боловсруулан, байгууллагын удирдлагаар батлуулан, мөрдөж ажиллах БУА-2021/06-ШТА-ГА

холбоотой 1, бусад шалтгаантай 60 тохиолдлыг бүртгэснээс урьдчилан сэргийлж чадсан 63, алдсан боловч хүний эрүүл мэндэд хохирол учруулалгүй сэргийлж чадсан 15 тохиолдол бүртгэгдсэн байна.

Дотоод хяналт шалгалтын багийн баталсан шалгалтын төлөвлөгөө, тохиолдлын бүртгэлд дүгнэлт хийхэд байгууллагын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгаж байгаа хэдий ч өгсөн зөвлөмж, алдаа зөрчлийн биелэлтийг тооцдог, давтан шалгалтыг хийдэг байх шаардлагатай байна.

Цаашид тохиолдлын тоог бууруулах чиглэлээр тодорхой үр дүнтэй ажил зохион байгуулж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах нь зүйтэй юм.

Дотоод хяналт шалгалтын багийн гишүүд өөрсдийн эзэмшсэн мэргэжлийн дагуу байгууллагын үндсэн үйл ажиллагаанд чиглэл, чиглэлээр зөвлөн туслах үйл ажиллагаа хийх, тохиолдол бүрд дүн шинжилгээ хийж, тохирсон сургалт зохион байгуулбал байгууллагын үйл ажиллагаа болон үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн баталгаа нэмэгдэх бололцоотой байна.

Аудитаар нийт 58.6 сая төгрөгийн зөрчил илэрсэнд хариуцлага тооцох 2, зөрчил арилгах 2 албан шаардлага, 5 зөвлөмжийг тус тус хүргүүлж ажиллалаа.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг эх хувиар нь мөн ЭМГ-аас биелэлтийг тооцож ажилласан тухай тэмдэглэл, албан тоотыг цаасаар болон цахимаар ирүүлэхийг удаа дараа шаардсан боловч холбогдох баримтыг ирүүлээгүй нь ковид-19, цар тахалтай холбон үзэж байгаа ч холбогдох асуудлыг дүгнэх боломжгүй, хийсэн ажлыг хийгээгүйгээр дүгнүүлэх зэрэг эрсдэл үүсгэж байна.
- Бүтэц орон тоог 100 хувиар батлуулж ажиллаагүй, 63 орон тоо буюу 20 хувиар дутуу орон тоогоор ажиллаж байна.
- НХХЯ-ны сайдын 2001 оны 03 дугаар тушаалаар батлагдсан “Нэг үйлчлэгчийн цэвэрлэх талбай, ажлын үлгэрчилсэн хэмжээ”-нд тусгагдсаны дагуу үйлдвэр үйлчилгээний газар гэхэд модон, дубэн, алаг чулуун, хулдаасан гэж 4 хэсэгт хувааж цэвэрлэх талбайн хэмжээг заасан байхад үйлчлэгчийн цэвэрлэх талбайг нарийн тооцож төлөвлөөгүй нэг үзүүлэлтээр төлөвлөж тооцсон байна.
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгаагаар 230.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж дутагдсанаас тухайн онд 18.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлжээ.
- Түргэн тусламжийн дуудлагын бүртгэлийг дутуу хөтөлсөн, байгууллагын даргын тушаалаар баталсан “Нэгдсэн эмнэлгийн түргэн тусламжийн ажиллах журам”-ын 6 дахь⁸, “Алсын түргэн тусламжийн дуудлагын үйлчилгээг зохицуулах журам”-ын 17 дахь⁹ гэсэн заалтуудыг холбогдох журмуудыг мөрдлөг болгож ажиллаагүй байна.
- Эмнэлгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ нь хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгчдэд эрүүл ахуйн шаардлага хангасан хоол хүнсээр бүрэн хангаагүй байна.
- Хүнсний материалыг гэрээгүй, тендер сонгон шалгаруулалтгүйгээр бэлтгэсэн байна.
- Иргэд олон нийтээс авахаар 12 санал асуулгыг бэлтгэн дүгнэхэд эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээ мэдээллийг иргэдэд хангалтгүй хүргэдэг, эмч сувилагчийн иргэдтэй харилцах харилцааны соёл муу, нарийн мэргэжлийн эмч дутмаг, иргэд нэгдсэн эмнэлгээр үйлчлүүлэхэд хувиасаа эм тариа авч үйлчилгээ авсан ч буцааж эм тарианы мөнгөө авч чаддаггүй, ЭМД сангаас төлбөрийг нь хариуцдаг тусламж үйлчилгээнд иргэд сэтгэл хангалуун байж чаддаггүй зэрэг үр дүн гарч байна.
- Хогийн савны багтаамж бага, хүрэлцээ муу, хогоо ил задгай хаяхгүй, гадна талбайд 30 м тутамд хогийн сав байрлуулах зэрэг зөвлөмж хүргүүлж ажилласан ч өнөөгийн байдалд уг зөрчил арилаагүй хэвээр байна.
- Мөн хогийг цаг тухайд нь зайлуулж ажиллаагүй, хогийн савны хүрэлцээ муу байгаа, эмгэг хогны битүүмжилсэн нүхийг дүүрэх болгонд нь шинээр нүх ухаж шинэчилж байгаа нь цаашлаад хөрсний бохирдол үүсгэх, эрүүл ахуйд нөлөөлж болзошгүй байна.

⁸ Дуудлагын эмч нь түргэн тусламжийн хуудас, зөвшөөрөгдсөн бүртгэл, хяналтын хууднуудыг бүрэн хөтөлсөн байна.

⁹ Алсын дуудлагын багийг томилогдсоноос хойш 30 минутын дотор бэлэн болгож гаргаагүй бол тухайн өдрийн дуудлага хүлээн авсан сувилагч нарт холбогдох хууль, тогтоомж байгууллагын дотоод журмыг үндэслэн урамшуулал, хариуцлагын арга хэмжээг тооцно.

- Нэгдсэн эмнэлгийн зарим тасгийн эмийн зарцуулалтын тайланг 2346.3 мянган төгрөгөөр илүү, дутуу зөрүүтэй тайлагнасан байна.
- Чанарын хяналтын багийн гишүүд хяналт шалгалт хийсэн тохиолдол бүрд дүн шинжилгээ хийж, оновчтой сургалт зохион байгуулбал байгууллагын үйл ажиллагаа, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн баталгаа нэмэгдэх бололцоотой нь харагдаж байна.
- Нэгдсэн эмнэлгийн дотоод хяналтын баг нь тухайн жил хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулан ажиллаагүй, иргэд олон нийтийн судалгаа, илэрч байгаа зөрчлүүдээс үзэхэд байгууллагын үйл ажиллагааны дотоод хяналт сулаас үр дүн, үр нөлөө бага байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга П.Оюунцэцэг, орлогч дарга Ө.Энхмаа, Ерөнхий нягтлан бодогч И.Энхжаргал,

- Дутагдаж байгаа тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх талаар яам, аймаг орон нутгийн удирдлагатай хамтран ажиллаж шийдвэрлэх.
- Түргэн тусламжийн дуудлагын бүртгэлийг үнэн зөв, бүрэн хөтөлж холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах.
- Хогийн савны хүрэлцээг нэмэгдүүлж журмын дагуу тэмдэг тэмдэглэгээг байршуулж ажиллах.
- Хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөнүүдийн хоолны мах болон сүүний чанарт хяналт тавьж шинжилгээнд бүрэн хамруулж ажиллах.
- Дотоод хяналт болон чанарын хяналтын багийн гишүүдийн ажлыг сайжруулах холбогдох журмын хэрэгжилтийг ханган биелэлтийг тооцож ажиллах.